




ДСЦТС ХК-ИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН





КОМПАНИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО,ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ



ДСЦТС ХК нь бодлого зохицуулалтын 7 хэлтэс, шуурхай удирдлага, ХЭМАБ, засвар туршилт, хэмжүүр тоолуур лабораторийн, тээвэр, үйлчилгээний чиглэлээр ажиллах 6 алба, тоног төхөөрөмжийн ашиглалт, борлуулалтын ажлыг эрхлэн гүйцэтгэх 5 салбар, хэрэглэгчдэд үйлчлэх 1 төвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.



КОМПАНИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГАА

Нийт ажилтнуудын **53.3%-ийг** 18-35 насны залуучууд, **36-61 насныхан 36.6 %-ийг** тус тус эзэлж байна. **Ажилтны дундаж нас: 36.5**

Ажилтнуудын насны ангилал	Тоо	Харьцаа
18-25 нас	35	8.5%
26-35 нас	182	44.7%
36-50	137	33.6%
51-60	51	12.5%
61-ээс дээш	2	0.5%


Ажилласан жилийн ангилал		
0-5 жил хүртэл	150	36.8%
6-10 жил	116	28.5%
11-15 жил	65	15.9%
16-20 жил хүртэл	30	7.3%
21-ээс дээш жил	46	11.3%

Хүйсийн харьцаа	Тоо	Харьцаа
Эрэгтэй	285	70%
Эмэгтэй	122	30%



2023 оны 5 сарын байдлаар компанийн хэмжээнд 178 удирдах болон ИТА /албан хаагч/, мэргэшлийн зэрэгтэй 23 ажилтан ажиллаж байгаа бөгөөд **62,9%** нь дээд боловсролтой ажилтнууд эзэлж байгаагаас 12 магистр, 17 ажилтан гадаадад мэргэжил, боловсрол эзэмшсэн байна.

Компанийн монтёруудын мэргэшлийн зэрэг, группын судалгаа



Мэргэшлийн зэрэг







СУРГАЛТ ХӨГЖИЛ

ХНХэлтсээс 2023 оны эхний хагас жилд 47 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 2848 хүн хамрагдсан байна.


Зохион байгуулсан 47 сургалт



Сургалтыг төлөвлөгөөний гүйцэтгэл



■ Биелэгдсэн ■ Биелэгдээгүй






КОМПАНИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАРАЛТЫН ЭРГЭЦ /2017-2023/

Он	2017	2018	2019	2020	2021	2022	2023/ 07
Нийт ажилтны тоо	433	442	442	442	445	445	442
Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон	58	54	61	33	53	70	63
Ажилтны санаачлагаар	54	49	53	31	48	59	61
Ажил олгогч санаачлагаар	4	5	8	2	5	11	2
Шилжилт хөдөлгөөний хувь	13.4%	12.2%	13.8%	7.5%	11.9%	15.7%	14.2%

2022-2023 онд 133 ажилтан ажлаас гарсан бол, 2023 оны 7дугаар сарын байдлаар 63 ажилтан гарсан нь өмнөх жилүүдийн бүтэн жилийн хүний нөөцийн гаралтын эргэцтэй тэнцэж байна. Ажлаас гарсан ажилтны 95% нь Гадаадад болон уурхайд ажиллахаар хөдөлмөрийн харилцаагаа дуусгавар болгосон байна.






Худалдан авсан ЦЭХ

2023 оны эхний хагас жилд нэг худалдан авагчаас 303.7 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авахаар төлөвлөснөөс 291.8 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авсан нь төлөвлөгөөнөөс 3.9%-иар буюу 11.9 сая кВт.цагаар буурсан байна.

Худалдан авсан ЦЭХ /сая.кВт.ц





Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өссөн дүн	
2022 оны гүйцэтгэл	сая кВт цаг	305.5	
2023 оны захиалга	сая кВт цаг	303.7	
2023 оны гүйцэтгэл	сая кВт цаг	291.8	
өмнөх оны гүйцэтгэлээс бууралт	биет	сая кВт цаг	(13.6)
	хувь	хувь	-4.5%
тухайн оны анхны захиалгаас	биет	сая кВт цаг	(11.9)
	хувь	хувь	-3.9%



Борлуулсан ЦЭХ

Эхний хагас жилийн хугацаанд гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөөгөөр 257,1 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулахаас 266,2 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч төлөвлөгөөний биелэлт 103,5%-тай байна.






Борлуулсан ЦЭХ

Хэрэглээний бууралтын бүтцийг хэрэглэгчийн ангилалаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал уул уурхайн хэрэглэгчдийн хэрэглээ өмнөх оноос 15,9 сая кВт.цагаар буюу 17%-ийн бууралттай, бусад аж ахуйн нэгж байгууллагын хэрэглээ өмнөх оноос 1,0 сая кВт цагаар буюу 1,0%-ийн бууралттай байна.

Ахуйн хэрэглэгчдийн хэрэглээ өмнөх жилийн гүйцэтгэлээс 6,6 сая кВт цагаар буюу 12,8%-ийн өсөлттэй байна.





Түгээлтийн алдагдал

Эхний хагас жилийн хугацаанд цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал 8,79% буюу 25,6 сая кВт.цаг болсон нь төлөвлөгөөт алдагдлыг /12,12%/ 3,3 нэгжээр буюу 11,2 сая кВт.цагаар бууруулсан байна.





ЦЭХ-ний орлого

Гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөөний дагуу 25,0 тэрбум төгрөгний орлого төвлөрүүлэхээс 26,7 тэрбум төгрөгийн орлого цуглуулж гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөө 106,8%-ийн гүйцэтгэлтэй байна.


Орлогын үзүүлэлт





2023 оны Их засвар, ТЗБАХ, ХО-ын ажлын гүйцэтгэл

2023 онд Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын 40 нэр төрлийн ажил төлөвлөснөөс 18 ажлыг бүрэн хийж ажлын гүйцэтгэл 45%-тай явагдаж байна. Хийгдэж байгаа 14 ажил, эхлээгүй 8 нэр төрлийн ажил байгаа бөгөөд эхлээгүй 8 ажлаас 3 ажлын материалыг худалдан авсан.



Д/д	Ажлын төрөл	Нийт төлөвлөсөн ажлын тоо	Эхлээгүй	Хийгдэж байгаа	Дууссан	Хувь
1	Их засвар	12	4	3	5	42%
2	ТЗБАХ	15	2	8	5	33%
3	Хөрөнгө оруулалт	13	2	3	8	62%
Дүн		40	8	14	18	45%







УРСГАЛ ЗАСВАР

2023 оны хагас жилийн байдлаар компанийн хэмжээнд урсгал засварын 142 ажлыг 1,049 тэрбум төгрөгөөр хийхээр төлөвлөснөөс 94 ажил буюу 42% гүйцэтгэсэн.

2023 оны хагас жилийн урсгал засварын ажлын графикайн мөрдөлт



2023 оны урсгал засвар гүйцэтгэл /төрөл, хувиар/








Тасралт саатал

2023 оны эхний хагас жилд компанийн хэмжээнд 120 удаа тасралт саатал гарсан бол тасралтын дундаж хугацаа 4,62 цаг, ДТЭХ 270328,99 кВт*цаг байгаа нь 2022 оны мөн үетэй харьцуулахад тасралт саатал 3-аар буурсан.

Тасралтыг өмнөх онуудын эхний хагас жилүүдтэй харьцуулахад:







ГЭМТЭЛ

2023 оны 2-р улиралд 69 гэмтэл, зөрчил гарсан. 2022 онтой харьцуулахад 28 гэмтэл зөрчлөөр буурсан.

Гэмтэл зөрчил





Гэмтлийн ангилал






Дуудлага

2023 оны эхний хагас жилийн байдлаар ахуйн 3071, ААН 115, дэд станц хуваарилах байгууламжийн 99, нийт 3285 дуудлага ирснийг барагдуулсан.



Дуудлагыг төрөл






Горим ажиллагаа, ачаалал

Зуны бага ачааллын хэмжилтээр $P_{max}=72.9$ МВт, $P_{min}=69.01$ МВт чадал авсан байна. Энэ нь өмнөх оны зуны бага ачааллын мөн үетэй харьцуулахад 7,42%-аар буурсан байна.

2023 оны зуны бага ачааллын хэмжилтээр хэт ачаалалд орсон шугам тоноглол болон фазын тэнцүүлэлт хийх шаардлагатай дэд станц байхгүй.

2023 оны зуны горимд 6/0,4 кВ-ын ТП-3, 9, 17, 20, 27, 30, 39, 63 Сүхбаатар салбарын ХТП-517 дэд станцуудын Т-1 болон Т-2 трансформаторууд зэрэгцээ ажиллаж байна.

ЗУНЫ БАГА АЧААЛЛЫГ СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР ХАРЬЦУУЛАХАД







Зураг төслийн ажлаар

2023 оны их засвар болон бусад ажлаар нийтдээ 15 зураг төслийн ажил гүйцэтгэсэн.

Төв аймаг, Заамар сум, Хайласт багт төлөвлөж буй 20км 35кВ-ын агаарын шугамын ажлын зургийг шинэ хийцлэлээр гүйцэтгэсэн.

Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Билгэх баг, “Оюут улаан” ХХК-ийн Хармагтай ажилчдын хотхоны гадна цахилгаан хангамж







Зураг төслийн ажлаар

Дархан Уул аймгийн Хонгор сум 2-р багт төлөвлөж буй Нарны станцыг тэжээх 35кВ-ын 1км агаарын шугам, 35/0,4кВ-ын 800кВА чадалтай дэд өртөөний ажлын зураг төсөл

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төвийн 4 дэд өртөөний 0.4кВ-ын ЦДАШ-ыг шинэчлэх иж бүрэн зураг төслийг боловсруулсан.





ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

2023 оны хагас жилийн байдлаар компанийн хэмжээнд 4524 ажлын захиалгаас хийгдээгүй 128 ажил хойшлогдсон байна.

Нарядаар 1921 ажил,

Шийдвэрээр 1847 ажил хийгдсэн

Зөрчилтэй 23 наряд байсныг зөрчлийг арилгуулан дахин олгуулж ажилд оруулсан байна.

Наряд шийдвэрээр хийгдсэн ажлуудыг салбар хэсэг нэгжээр харуулбал:





График- ХАБЭА I, II-р шатны үзлэгийн тоо





ДҮГНЭЛТ

2023 оны эхний хагас жилд нэг худалдан авагчаас 303.7 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авахаар төлөвлөснөөс 291.8 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авсан нь төлөвлөгөөнөөс 3.9%-иар буюу 11.9 сая кВт.цагаар буурсан байна.

2023 оны эхний хагас жилийн хугацаанд гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөөгөөр 257,1 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулахаас 266,2 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч төлөвлөгөөний биелэлт 103,5%-тай байна.

Гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөөний дагуу 25,0 тэрбум төгрөгний орлого төвлөрүүлэхээс 26,7 тэрбум төгрөгийн орлого цуглуулж гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөө 106,8%-ийн гүйцэтгэлтэй байна.

2023 онд Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын 40 нэр төрлийн ажил төлөвлөснөөс 18 ажлыг бүрэн хийж ажлын гүйцэтгэл 45%-тай явагдаж байна. Хийгдэж байгаа 14 ажил, эхлээгүй 8 нэр төрлийн ажил байгаа бөгөөд эхлээгүй 8 ажлаас 3 ажлын материалыг худалдан авсан.

2023 оны хагас жилийн байдлаар компанийн хэмжээнд урсгал засварын 142 ажлыг 1,049 тэрбум төгрөгөөр хийхээр төлөвлөснөөс 94 ажил буюу 42% гүйцэтгэсэн.



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

